

**N I BANK**  
ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК

[www.nibank.mn](http://www.nibank.mn)

**Жилийн тайлан**  
**2020**



# АГУУЛГА

**Товч танилцуулга**

**Эдийн засгийн орчин**

**Банкны салбарын тойм**

**Банкны зохистой засаглал**

Компанийн бүтэц

Төлөөлөн удирдах зөвлөл

Удирдлагын баг

Шинэ бүтээгдэхүүн

Эрсдэлийн удирдлага

Нийгмийн хариуцлага

**Аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан**

Хараат бус аудиторын тайлан

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид харилцагчдаа дээдлэн, итгэлцлийг эрхэмлэн, санхүүгийн цогц үйлчилгээг шинэлэг хэлбэрээр баяжуулан түгээж, тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулсан бүтээлч банк байна.

## АЛСЫН ХАРАА

Үндэсний баялаг бүтээгчдийн түнш, хөрөнгө оруулалтаараа тэргүүлэгч банк байна.





## ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

Гадаад эдийн засгийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн уналт Ковид-19 цар тахлын нөлөөгөөр дэлхийн эдийн засгийн төлөв улам хурдацтайгаар муудаж, ОПЕКийн орнуудын хэлэлцээр амжилтгүй болсон нь түүхий эд, металлын үнийн бууралтад голлох нөлөөг үзүүлэв. Монгол Улсын ДНБ 26.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 953.5 (3.5%) тэрбум төгрөгөөр 2010 оны зэрэгцүүхувиар тус тус буурлаалэх үнээр 7.3.

2020 онд суурь металлын үнэ 17 орчим хувиар, түүхийн нефтийн үнэ 40 орчим хувиар уналаа. Энэ онд дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөв саарч, түүхий эдийн эрэлт буурах хандлагатай тул зэс, төмрийн хүдэр, газрын тосны үнийн төсөөлөл буурч, алтны үнэ нэмэгдэв.

Ковид-19 цар тахлаас шалтгаалан БНХАУруу хийгдэх нүүрс, газрын тосны экспорт 2020 оны 2-4 дүгээр сард тасалдсан нь уул уурхайн экспортын хэмжээг ихээхэн бууруулав. Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, нефтийн бүтээгдэхүүний импорт агшсанаар нийт импорт буурав. Импортын бууралтыг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 7.9 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний бууралт 4.5 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний бууралт 2.8 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна. Ковид-19 цар тахал, түүнээс сэргийлэх хорио цээрийн арга хэмжээний нөлөөгөөр эдийн засгийн идэвхжил саарч, нүүрс, газрын тосны экспорт саатсан, барааны импортоос орох татварын орлого буурсан зэрэг нь орлого буурахад нөлөөлөв.

## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

- › Монголбанк 2020 онд багтан Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын “Саарал жагсаалт”-аас гарлаа.
- › Мөчлөг сөрсөн хэлбэрээр мөнгөний бодлогыг зөөлрүүлж, бодлогын хүүг түүхэн доод түвшин болох 6 хувьд хүргэв.
- › Гадаад валютын албан нөөц (ГВАН) 4.5 тэрбум ам.долларын босгыг давлаа.
- › Монголбанк 2020 онд түүхэн дээд хэмжээ буюу 23.6 тонн үнэт металл худалдан авлаа.
- › Номад бондыг гаргах, Мазаалай, Чингис бондын тодорхой хэсгийг дахин санхүүжүүлэх ажилд Монголбанк Засгийн газартай хамтарч ажиллав.
- › Монгол Улс ОУВС-тай хамтын ажиллагаагаа амжилттай үргэлжлүүлж, “Шуурхай санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд эх үүсвэр авав.


### ОНЦЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

 ДНБ -7.3%

**17.2% наяд төгрөг**  
Нийт хадгаламж

 ИМФЛЯЦИ 3.5%

**11.8%**  
Чанаргүй зээлийн хувь

 ГАДААД ХУДАЛДАА  
1969 сая ам.доллар

**3723 сая ам.доллар**  
Гадаад валютын нөөц



# БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

Ковид-19 цар тахлын тархалтаас урьдчилан сэргийлэхтэй холбогдуулан Засгийн газраас авсан арга хэмжээний хүрээнд хил хааж, хорио цээрийн дэглэм тогтоосноор экспортын үйл ажиллагаа зогсонги байдалд орох, бөөний болон жижиглэн худалдааны нийлүүлэлт буурах, хүнсний бус худалдааны салбар, тээвэр, түрээс, үйлчилгээний салбарын орлого тасалдах зэрэг сөрөг үр дагаврууд гарч байна. Үүнтэй холбоотойгоор 2020 оны байдлаар нийт 129.2 мянган зээлдэгчийн 5.06 их наяд төгрөгийн зээлийн эргэн төлөлтөд хүндрэл үүсээд байна. Улмаар зээлдэгчдэд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор Монголбанкнаас зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах, зээлийн ангиллыг тодорхой хугацаанд бууруулахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд 2020 оны байдлаар банкны системд 92.8 мянган зээлдэгчийн 2.6 их наяд төгрөгийн зээлийн бүтцэд өөрчлөлт оржээ.

## ЗЭЭЛ ОЛГОЛТ:




## ОНЦЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

Ковид-19 цар тахлын нөлөөнд өртсөн зээлүүдийн 53.7 хувийг том ААН-үүдийн, 36.9 хувийг иргэдийн, 8.4 хувийг жижиг, дунд ААН-үүдийн зээл тус тус бүрдүүлсэн байна.

Банкны системийн зээлийн чанарыг эдийн засгийн салбараар нь авч үзвэл 2020 оны байдлаар уул уурхайн салбарын зээлийн үлдэгдлийн 61.5 хувь буюу 862.3 тэрбум төгрөгийн зээл хэвийн ангилалд, 8.7 хувь буюу 122.6 тэрбум төгрөгийн зээл анхаарал хандуулах ангилалд, 29.8 хувь буюу 417.7 тэрбум төгрөгийн зээл чанаргүй ангилалд бүртгэгдсэн байна. Боловсруулах салбарын зээлийн хувьд 68.9 хувь буюу 957.5 тэрбум төгрөгийн зээл хэвийн ангилалд, 4.1 хувь буюу 56.4 тэрбум төгрөгийн зээл анхаарал хандуулах ангилалд, 27.0 хувь буюу 375.0 тэрбум төгрөгийн зээл чанаргүй ангилалд бүртгэгдсэн байна.

## ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ:



# ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Харилцах дансны хүүг тэглэсний нөлөөгөөр 15 хувь нь хугацаагүй хадгаламжид шилжлээ.

Бодлогын хүүг 6 хувьд буулгаснаар зээлийн хүү 15 орчим хувь, хадгаламжийн хүү 10 орчим хувьд хүрэх төлөвтэй.

8-р сарын сүүлээр банкууд иргэдийн зээлийн хүүгээ 1 хүртэлх хувиар буурууллаа. Зээлийн хүү 2021 онд дахин буурахаар байна.

Хорио цээрийн дэглэм суларсантай холбоотой 9-р сард банкуудын зээл олголт жилийн 22 хувиар өсөв. Гэсэн хэдий ч оны төгсгөлд эргэн буурах төлөвтэй байна.

Банкны системийн зээлийн багцын 18 хувийг асуудалтай зээл эзэлж байна. Дотоодод хөл хорио тогтоосонтой холбоотой цаашид огцом нэмэгдэх төлөвтэй байна.

Цалин, тэтгэврийн зээл олголт жилийн 12 хувь өссөн бол бизнесийн зээл дотроо уул уурхайн зээл 126 хувиар тус тус өсжээ



**35.3 их наяд ₮**  
Нийт актив



**11.4%**  
Чанаргүй зээлийн хувь





**17.4 их наяд ₮**  
Нийт зээлийн багц



**16.1 их наяд ₮**  
Нийт хадгаламжийн үлдэгдэл

# КОМПАНИЙН БҮТЭЦ



# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Үндэсний Хөрөнгө Оруулалтын Банкны Төлөөлөн удирдах зөвлөл/ТУЗ/ нь 5 гишүүний бүрэлдэхүүнтэй. ТУЗ-ийн даргыг түр орлон гүйцэтгэгчээр хатагтай С.Оргилмаа, гишүүдээр Б.Тулга, Хидэтоши Тоноока, Ж.Цэдэнрагчаа, Б.Отгонсүрэн нарыг бүрэлдэхүүнтэй.

Банк санхүүгийн салбарын арвин туршлагатай мэргэжилтнүүд ажиллаж байна. Үндэсний хөрөнгө оруулалтын банкны ТУЗ-ийн дарга болон гишүүд нь банкны хувьцаа эзэмшигч биш.

## С.Оргилмаа ТУЗ-ийн даргыг түр орлон гүйцэтгэгч

С.Оргилмаа нь 2018 оны 9 дүгээр сараас Үндэсний хөрөнгө оруулалтын банкны ТУЗ-ийн даргыг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байна. Мөн тус банкнаас гадна “Нэйшнл Инвестмент Менежмент” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын албан тушаалыг 2016 оноос хойш хашиж байна. Тэрээр эрх зүйч мэргэжилтэй бөгөөд санхүүгийн салбарт хуулийн чиглэлээр ажилласан 20 гаруй жилийн туршлагатай. Санхүүгийн байгууллагад Хуулийн зөвлөх, Хуулийн хэлтсийн захирал, Тамгын газрын захирал, Эрх зүй, захиргаа хариуцсан газрын захирал, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр тус тус ажиллаж байсан.

## Б.Тулга ТУЗ-ийн гишүүн

Б.Тулга нь 2018 оны 7 дугаар сараас ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Түүнчлэн тус банканд 2011 оноос эхлэн ажиллаж Санхүү хариуцсан захирал, Байгууллагын газрын захирлаар ажиллаж байсан ба 2017-2020 онуудад гүйцэтгэх захирлын албан тушаал хашиж байсан. Тэрээр бизнесийн эдийн засагч мэргэжилтэй. Банк санхүүгийн салбарт эрсдэлийн удирдлага, зээлийн удирдлага, санхүүгийн удирдлага болон банкны удирдлагын чиглэлээр ажиллаж байсан туршлагатай.

## Hidetoshi Tonooka ТУЗ-ийн гишүүн

Hidetoshi Tonooka нь тус банканд 2015 оноос ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Санхүү, үл хөдлөх хөрөнгийн /хосолсон/ чиглэлээр магистрын зэрэгтэй. Lehman Brothers Japan Inc, Goldman Sachs (Japan) Ltd, TPG Capital зэрэг санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр салбартаа тэргүүлэгч компаниудад 10 гаруй жил ажилласан туршлагатай. Мөн тус банкнаас гадна Sherpa Co.,Ltd-н компанид Гүйцэтгэх захирлын албан тушаал хашдаг болно.

## Ж.Цэдэнрагчаа ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэл захирал

Ж.Цэдэнрагчаа нь тус банканд 2020 оны 5 дугаар сараас Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүнээр тус тус томилогдон ажиллаж байна. Тэрээр маркетингийн менежмент мэргэжилтэй. Япон, Тайланд болон Англи улсуудад мэргэжлийн сургалтуудад хамрагдсан. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны Орон тооны бус гишүүн, Инвестос ББСБ-д ерөнхий захирал болон бусад байгууллагад ажиллаж байсан туршлагатай.

## Д.Отгонсүрэн ТУЗ-ийн хараат бус гишүүн

Б.Отгонсүрэн нь 2020 оны 5 дугаар сараас ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Мөн тус банкнаас гадна “Жи Си Ар Монгол” ХХК-ийн Төслийн зардлын хянагчийн албан тушаал хашдаг болно. Тэрээр банк санхүүгийн салбарт эрсдэлийн удирдлага, дүн шинжилгээ, нягтлан бодох бүртгэл болон аудитын чиглэлээр мэргэшсэн олон улсын арвин туршлагатай. Эрнист янг аудитын компани, Дэлхийн банк, Монголбанк зэрэг байгууллагад ажиллаж байсан.

## М.Цэндпүрэв ТУЗ-ын нарийн бичгийн дарга

# УДИРЛАГЫН БАГ



**Ж.Цэдэнрагчаа**  
Гүйцэтгэх захирал



**О.Одгэрэл**  
Эрдэлийн хяналтын газрын захирал



**Ч.Баатар**  
Актив пассивын удирдлагын газрын захирал



**Ю.Оюунжаргал**  
Захиргаа, хүний нөөцийн газрын захирал



**Ж.Мөнхзаяа**  
Үйл ажиллагааны удирдлагын газрын захирал



**Т.Халиунаа**  
Санхүү бүртгэл, тайлагналын газрын захирал



**А.Аръяажав**  
Стратеги төлөвлөлт, бизнесийн газрын захирал



**С.Лхагвасүрэн**  
Мэдээлэл технологийн газрын захирал




**О.Төгсжаргал**  
Дотоод аудитын хэлтсийн захирал




**У.Сарантуяа**  
Салбарын удирдлагын газрын захирал




# ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН




“ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ” зорилтот хуримтлал гэж харилцагч хүүхдэдээ чанартай боловсрол эзэмшүүлэхийн тулд ирэх жилийн сургалтын төлбөрийг бүрдүүлэхэд зориулсан мөнгөн хуримтлалыг хэлнэ




“ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ” зорилтот хуримтлал гэж харилцагч хүүхдэдээ чанартай боловсрол эзэмшүүлэхийн тулд ирэх жилийн сургалтын төлбөрийг бүрдүүлэхэд зориулсан мөнгөн хуримтлалыг хэлнэ




“БАКАЛАВР” зорилтот хуримтлал гэж харилцагч өөрийн болон хүүхдийнхээ ирээдүйн Бакалаврын боловсрол эзэмшихэд зориулсан мөнгөн хуримтлалыг хэлнэ.




“БАКАЛАВР” зорилтот хуримтлал гэж харилцагч өөрийн болон хүүхдийнхээ ирээдүйн Бакалаврын боловсрол эзэмшихэд зориулсан мөнгөн хуримтлалыг хэлнэ.




“МАГИСТР” зорилтот хуримтлал гэж харилцагч өөрийн ирээдүйн Магистрын зэрэг хамгаалах зорилгодоо хүрэхийн тулд сургалтын төлбөрийг бүрдүүлэхэд зориулж буй мөнгөн хуримтлалыг хэлнэ



“МАГИСТР” зорилтот хуримтлал гэж харилцагч өөрийн ирээдүйн Магистрын зэрэг хамгаалах зорилгодоо хүрэхийн тулд сургалтын төлбөрийг бүрдүүлэхэд зориулж буй мөнгөн хуримтлалыг хэлнэ



“ХАМТЫН АЯЛАЛ” зорилтот хуримтлал гэж гэр бүл, найз нөхөд, хамт олноороо хамтран дотоод болон гадаадад аялах зорилгоор бүрдүүлж буй мөнгөн хуримтлалыг хэлнэ.




“ХАМТЫН АЯЛАЛ” зорилтот хуримтлал гэж гэр бүл, найз нөхөд, хамт олноороо хамтран дотоод болон гадаадад аялах зорилгоор бүрдүүлж буй мөнгөн хуримтлалыг хэлнэ.




“ХАМТЫН ЗОРИЛГО” зорилтот хуримтлал гэж гэр бүл, найз нөхөд, ах дүү нар хамтын зорилго дэвшүүлэн түүндээ хүрэх зорилгоор бүрдүүлж буй мөнгөн хуримтлалыг хэлнэ.



“ХАМТЫН ЗОРИЛГО” зорилтот хуримтлал гэж гэр бүл, найз нөхөд, ах дүү нар хамтын зорилго дэвшүүлэн түүндээ хүрэх зорилгоор бүрдүүлж буй мөнгөн хуримтлалыг хэлнэ.



“АВТОМАШИН ХУДАЛДАН АВАХ” зорилтот хуримтлал гэж автомашин худалдан авахад зарцуулагдах мөнгөн хуримтлалыг хэлнэ.



“АВТОМАШИН ХУДАЛДАН АВАХ” зорилтот хуримтлал гэж автомашин худалдан авахад зарцуулагдах мөнгөн хуримтлалыг хэлнэ.



## Эрсдэлийн удирдлага

### ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

**Б**анк нь харилцагч, хувь нийлүүлэгчийн мөнгөн хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх үүргийг хүлээхээс гадна ашгийн төлөөх бизнесийн байгууллага болохын хувьд стратеги төлөвлөгөөнд нийцүүлэн ашигт ажиллагааг хангахад чиглэсэн эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдүүлэхэд онцгойлон анхаарч ажилладаг.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь эрсдэлийг удирдахад чиглэсэн үйл ажиллагаа, тэдгээрийг хэрэгжүүлэх, зохицуулах бодлого, дүрэм, журам, болон банкны нэгжүүд, ажилтан бүрийн үүрэг хариуцлагыг оновчтой тодорхойлсон бүтэц зохион байгуулалт, эрсдэлийн хяналтыг хэрэгжүүлэх зохистой системээс бүрдэнэ.

Банкны Эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах, үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор 2020 оны 04 дүгээр сараас эхлэн банкны бүтэц, зохион байгуулалтыг шинэчилж Гүйцэтгэх захирлын дэргэд Эрсдэлийн Удирдлагын хороо, түүний шууд удирдлагад Эрсдэлийн хяналтын газарыг тус тус байгуулан ажиллаж эхэлсэн.

Гүйцэтгэх захирлын дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо нь банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлтэй нөхцөл байдал, үүссэн эрсдэлийн тохиолдлыг хянах, бууруулах, үр дагаврыг хамгийн бага байлгах зорилгоор тодорхой төрлийн асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж байна.

Аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, хүлээн зөвшөөрөх, эсхүл шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Төлөөлөн удирдах зөвлөлөөс тодорхойлсон хязгаарын дотор Гүйцэтгэх удирдлагын харьяа нэгжүүд нь дараах үндсэн чиглэлээр эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж байна.





# ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

## Зээлийн эрсдэлийн удирдлага

Банкны зээлийн эрсдэлийн удирдлага нь зээлийн үйл ажиллагаанаас үүсч болох зээл чанаргүйдэх болон зээлийн багцын төвлөрлийн эрсдэлийг оновчтой түвшинд барихад чиглэдэг ба зээлийн үйл ажиллагааг зохицуулагч байгууллагаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдэд нийцүүлэх, зээлийн эрсдэлийг тооцох, барьцаа хөрөнгийн үнэлгээний аргачлалуудыг сайжруулахад чиглэж байна.

Төвлөрлийн эрсдэлийг удирдахын тулд эрсдэлийг зохистой тараан байршуулсан зээлийн багц бүрдүүлэхийг эрмэлзэж, эдийн засгийн тодорхой нэг салбар, хувь хүн болон банкны холбогдох этгээдэд их хэмжээний зээл олгохоос зайлсхийж хязгаарлалтыг оновчтой тогтоох нэн тэргүүний зорилт тавьж ажиллаа.

Цаашид төвлөрлийн эрсдэлийг бууруулах үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлэн зээлийн багцын эрсдэл өндөртэй том зээлүүдийг бууруулж зээлийн багцын оновчтой бүтцийг бий болгохоор зорин эрсдэлийн удирдлагын тогтолцоог улам сайжруулж ажиллахаар зорьж байна.

Мөн банкны ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор зээлийн эргэн төлөлтөд чиглэсэн хэвийн процессоор төлүүлэх боломжгүй, мэргэшсэн ажилтнуудын оролцоо шаардлагатай чанаргүй зээл, түүнтэй адилтгах активыг барагдуулахаар Тусгай активын газар болон Эрсдэлийн хяналтын газрын хуульч нараас бүрдсэн баг ажиллаж байна.

## Хууль эрх зүй, Комплаенсийн эрсдэлийн удирдлага

Банк нь олон улсын болон дотоодын эрх бүхий байгууллагуудаас гаргасан дүрэм журам, стандарт шаардлага, хууль тогтоомж тэдгээрт нийцүүлэн боловсруулсан банкны өөрийн бодлого, журам, ёс зүйн дүрэмийг хэрэгжүүлж ажилладаг.

Хууль эрх зүйд үл нийцэх, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг мэргэжлийн түвшинд хараат бусаар гүйцэтгэх зорилгоор Эрсдэлийн хяналтын газар, Комплаенсийн чиг үүрэг хэрэгжүүлэгч ажилтнууд нь Гүйцэтгэх захирлын шууд удирдлагад харьяалагддаг бөгөөд шаардлагатай тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодод шууд хандах, тайлагнахаар бүтэц зохион байгуулалтыг баталсан нь Комплаенсийн эрсдэлийн удир.

## Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага

Банк болон банкны харилцагчийн мэдээллийн нууцлалыг хангах зорилгоор гадны цахим халдлагаас сэргийлэх систем, бодлого болон дотоод ситемийн хэрэглэгч нарын системд хандах эрхийн зохицуулалтыг тогтмол шинэчлэн хэрэглээний төлөв, хандалтаас үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлж хяналт хэрэгжүүлэн ажилласан.

Мөн банкны мэдээллийн технологийн үйл ажиллагааг зохицуулагч байгууллагаас тогтоосон мэдээллийн аюулгүй байдлын стандартад нийцүүлэхэд анхаарч ажиллахын зэрэгцээ олон улсын COBIT-5 стандартыг нэврүүлэхээр холбогдох бодлого журмыг шинэчлэн баталж мэдээллийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагааны үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэхээр зорьж байна.



## Актив, пассивын эрсдэлийн удирдлага

Харилцагч, хувь нийлүүлэгчээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн аюулгүй байдлыг хангах, эрсдэл багатай активт байршуулах, түүнийг үр ашигтай зарцуулж, үнэ цэнийг нэмэгдүүлэх нь нэн тэргүүний зорилт болохын хувьд хөрөнгө зохицуулалтын үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд явуулах, төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж орлого, зарлагын харьцааг зохистой байлгах богино хугацааны төлөвлөгөөг дэвшүүлэн ажилласан болно.

Мөн банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээг нэмэгдүүлж, зохицуулагч байгууллагаас баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж, үр дүнг тогтвортой хадгалах нь урт хугацааны зорилт юм.

## Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Банкны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага нь дотоод үйл ажиллагаа, системүүдийн хангалтгүй байдал, гадаад орчны нөлөөлөл болон хүний хүчин зүйлээс шалтгаалсан банкны нэгжүүдийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлон бууруулахад чиглэдэг.

Ажилтан бүр, нэгж бүр өөрийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэлийг хэрхэн хянаж, илрүүлэх, мэдээлэх, оновчтой арга хэмжээг хэрэгжүүлэх тухайд зохих мэдлэг, мэдээлэлтэй байхыг тэргүүн зорилт болгож, ажилтан бүрийн эрсдэлд хандах хандлагыг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулахад тухайлан анхаарч ажиллаж байна.





# НИЙГМИЙН

## ХАРИУЦЛАГА



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ



Сэтгэл, итгэлээр дэмжиж  
байгаа ААН, иргэддээ  
баярлалаа

Өндөржүүлсэн бэлэн байдлын үед цаг наргүй, ээлжгүй ажиллаж буй эмч, эмнэлгийн ажилтан, эрүүл мэндийн байгууллагынханд сэтгэл санааны болон эд материалын дэмжлэг үзүүлж буйгаа зарим иргэн, ААН-үүд мэдэгдсээр байна.

Тухайлбал: Үндэсний хөрөнгө оруулалтын банкнаас "Ажилтны 10 мянган төгрөг" сайн дурын аян зарлаж, 1 сая нэг зуун тавин мянган төгрөг цугласныг ЭМЯ-нд гардууллаа. Аюулт өвчний харанга дэлдсээр буй энэ цаг мөчид иргэний үүрэг хариуцлагаа ухамсарлахын сацуу халуун цэгт ажиллаж буй эмч, эрүүл мэндийн байгууллагынхныг дэмжиж, итгэл, сэтгэлийн хандив өргөсөн Үндэсний хөрөнгө оруулалтын банкны хамт олонд талархаж буйгаа ЭМЯ нийт эмч, эмнэлгийн ажилтнуудынхаа өмнөөс илэрхийлж байна. Монголчууд бид хамтын хариуцлага, нэгдмэл сэтгэлээр энэхүү эрсдэлт өвчнийг хохирол багатай туулж чадах бөгөөд амралтын өдрүүдэд анхаарал, болгоомжлолоо алдахгүй байхыг нийт ард иргэддээ уриалж байна.

# АУДИТЫН ТАЙЛАН

## ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК ХХК

Аудитлагдсан санхүүгийн тайлан  
2020 оны 12 дугаар сарын 31



# ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН



### ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

“Үндэсний хөрөнгө оруулалтын банк” ХХК-ийн хувьцаа эзэмшигчидэд

#### Хязгаарлалттай Дүгнэлт

Бид “Үндэсний хөрөнгө оруулалтын банк” ХХК (“Компани”)–ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэнээс үүссэн нөлөөнөөс бусдаар санхүүгийн тайлангууд нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)–ын дагуу материаллаг алдаагүй, үзэн зөн толивуулсан байна.

#### Хязгаарлалттай Дүгнэлтийн Үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)–уудын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудитын үүрэг хариуцлага” хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

#### Онцлох Асуудал – Тасралтгүй үйл ажиллагаа

Өмчийн өөрчлөлтийн тайланд анхаарлаа хандуулж байна. Энэ нь банкны 2020 онд цэвэр ашиг 12,163,308.4 мян.төг, (2019 онд алдагдал 69,203,336.4 мян.төг) байгаа бөгөөд өнөөдрийг хүртэл нийт өр төлбөрийн дүн нь нийт өөрийн хөрөнгөөс 74,045,968.2 мян.төг-өөр (2019 онд 85,682,175.3 мян.төг) давсан байна. Эдгээр үйл явдал, нөхцөл байдал болон бусад асуудлын хамт Компани үйл ажиллагаагаа цаашид үргэлжлүүлэн хийх чадвартай болоход ихээхэн эргэлзээ төрүүлж болохуйц тодорхой бус байдал байгааг харуулж байна. Энэ асуудлаар бидний санал дүгнэлт өмнөх оныхоос оорчлогдоогүй болно.





## ОНЦЛОХ АСУУДАЛ – ТАСРАЛТГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА (үргэлжлэл)

### Бусад асуудал – Болзошгүй өр төлбөр

Банк нь холбоотой этгээдүүдийн үйл ажиллагаанаас үүдэлтэй томоохон дүнтэй эзэл, авлагын эргэн төлөлтийн хангалтгүй байдал, эзэлийн барьцааны дутагдал зэргээс их хэмжээний алдагдал хүлээн зөвшөөрөх магадлалтай байна.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, тайлант онд гарч байсан төлбөр гүйцэтгэлийн саатлаас хамааран богино хугацаанд төлбөр гүйцэтгэлийн эрсдэлд орж болзошгүй.

Бид уг асуудлыг удирдлагын анхааралд хүргэж байгаа бөгөөд, энэхүү асуудлаар дүгнэлтээ өөрчлөөгүй болно.

### Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг дүнг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

### Санхүүгийн тайлангийн аудитал хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

## Санхүүгийн тайлангийн аудитал хүлээх аудиторын үүрэг хариуцлага (үргэлжлэл)

Зохистой баталгаажуулалт гэдэг нь ондөр түвшний баталгаажуулалт боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлж гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэгсэлчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл илгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэн болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхиулах, буруу мэдээлэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор бичиг тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэгцээн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадмажид мэдэгдэхүйц эргэлтээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

### Бусад

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор бич, Монгол улсын Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд заасны дагуу компанийн захиралгаар аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчид зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд аливаа гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

  
Д.ШИЙРЭВ

"Шонхор үнэмж Аудит" ХХК  
Монгол Улс, Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг, 6-р зороо  
Метробизнес төв, Сүхбаатар-13  
6-р давхар, 603 тоот

Огноо: 2021. 03. 30

Утас: 80110088, 70150001  
Вэб: www.shonkhor.mn  
Имэйл: shonkhor.mn@gmail.com

## ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК ХХК

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр

Санхүүгийн байдлын тайлан

	2020	2019
<b>ХӨРӨНГӨ</b>		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,004,434.00	33,802.68
Банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	-	-
<b>Хөрөнгө оруулалт</b>	<b>2,538,647.40</b>	<b>2,702.58</b>
Ариилжааны үнэт цаас	-	-
Борлуулахад бэлэн үнэт цаас	7,535,004.40	7,409.50
Үнэт цаасны эрсдэлийн дүн	(4,996,357.00)	(4,706.92)
<b>Зээл (цэвэр дүнгээр)</b>	<b>29,605,653.40</b>	<b>41,129.72</b>
Хэвийн зээл	5,620,916.20	15,628.89
Хугацаа хэтэрсэн зээл	3,749,562.60	4,277.26
Хэвийн бус зээл	16,824,291.30	17,647.32
Эргэлзээтэй зээл	8,151,834.20	9,297.29
Муу зээл	59,543,144.50	60,995.51
Зээлийн хойшлогдсон төлбөр	(12,860.60)	(356.06)
Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	1,579,536.20	1,213.95
Зээлийн эрсдэлийн сан	(65,850,771.00)	(67,894.88)
<b>Бусад санхүүгийн хөрөнгө</b>	<b>30,909,681.90</b>	<b>11.88</b>
<b>Бусад санхүүгийн бус хөрөнгө</b>	<b>1,027,617.80</b>	<b>554.79</b>
<b>Үндсэн хөрөнгө</b>	<b>11,577,082.60</b>	<b>12,622.05</b>
<b>Борлуулах зориулалттай хөрөнгө</b>	<b>2,123,234.90</b>	<b>49,992.84</b>
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>4,956,347.30</b>	<b>10,101.95</b>
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>101,310,037.10</b>	<b>105,918.50</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Харилцах</b>	<b>112,688,710.50</b>	<b>80,719.14</b>
Харилцах дансны нэрлэсэн үлдэгдэл	112,688,022.20	80,718.46
Харилцах дансанд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	688.30	0.68
<b>Хадгаламж</b>	<b>27,091,185.00</b>	<b>94,368.40</b>
Хугацаагүй хадгаламж	6,857,513.20	50,342.43
Хугацаатай хадгаламж	19,421,954.00	36,172.73
Бусад төрлийн хадгаламж	-	5,498.69
Хадгаламжинд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	811,717.80	2,354.56

## ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК ХХК

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр

Санхүүгийн байдлын тайлан

мян.төг

	2020	2019
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	16,714,162.70	2,888.62
Бусад эх үүсвэр	1,311,548.70	1,928.15
Бусад санхүүгийн өр төлбөр	2,062,447.30	1,640.99
Бусад санхүүгийн бус өр төлбөр	487,951.00	10,055.37
Хоёрдогч өр төлбөр	15,000,000.00	-
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>175,356,005.30</b>	<b>191,600.68</b>
<b>ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Хувь нийлүүлсэн хөрөнгө</b>	<b>35,130,000.80</b>	<b>35,130.00</b>
Давуу эрхийн хувьцаа	-	-
Энгийн хувьцаа	35,130,000.80	35,130.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	4,260,124.70	4,260.12
Хуримтлагдсан ашиг, алдагдал	(113,436,093.70)	(125,072.30)
<b>Өөрийн хөрөнгийн дүн</b>	<b>(74,045,968.20)</b>	<b>(85,682.18)</b>





## ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК ХХК

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр

Орлогы дэлгэрэнгүй тайлан

	2020	2019
<b>Хүүгийн орлого</b>	2,935,255.60	16,754,275.20
Монгол банкинд байршуулсан хөрөнгийн	-	582,206.30
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	188,456.40	4,896,325.40
Үнэт цаасны	147,856.60	2,347,811.40
зээлийн	2,598,942.60	8,927,932.10
<b>Хүүгийн зардал</b>	7,968,992.40	23,147,627.90
Харилцахад төлсөн хүү	2,195,538.90	2,734,352.80
Хадгаламжинд төлсөн хүү	4,656,012.80	16,477,228.60
Зээлийн хүүгийн зардал	391,630.70	996,833.30
Үнэт цаасны хүүгийн зардал	706,001.00	2,837,434.40
Бусад хүүгийн зардал	19,808.90	101,778.80
<b>ЦЭВЭР ХҮҮГИЙН ОРЛОГО [(1)-(2)]</b>	<b>(5,033,736.80)</b>	<b>(6,393,352.70)</b>
<b>Эрсдэлийн сангийн зардал</b>	2,206,150.10	30,099,856.80
Үнэт цаасны	925,425.70	4,706,923.90
Зээлийн	1,280,724.40	25,392,932.90
<b>Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого [(3)-(4)]</b>	<b>(7,239,886.90)</b>	<b>(36,493,209.50)</b>
<b>Бусад орлого</b>	88,803,603.40	54,369,121.10
Хүүгийн бус орлого	64,076,272.40	51,100,717.90
Арилжааны орлого	601,554.10	377,179.20
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого	62,511,366.70	48,621,787.90
Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	963,351.50	2,101,750.80
бусад орлого, олз	24,727,331.00	3,268,403.20
<b>Бусад зардал</b>	69,394,517.40	86,982,117.90
<b>Хүүгийн бус зардал</b>	68,219,024.90	86,768,074.00
Бусад эрсдэлийн сангийн зардал	49,750.40	19,598,869.80
Арилжааны зардал	55,008.90	256,286.40
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал	63,873,528.40	48,564,432.70
Хураамж, шимтгэлийн зардал	134,532.70	315,673.90
Үйл ажиллагааны бусад зардал	4,106,204.40	18,032,811.20
Бусад зардал, гарз	1,175,492.50	214,043.90
<b>Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)</b>	12,169,308.40	(69,106,206.30)
Орлого татварын зардал	3,890.80	97,130.10
<b>Татварын дараах ашиг, алдагдал (8-9)</b>	<b>12,165,908.00</b>	<b>(69,203,336.40)</b>
<b>Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал (10+11)</b>	<b>12,165,908.00</b>	<b>(69,203,336.40)</b>
<b>Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (12+13)</b>	<b>12,165,908.00</b>	<b>(69,203,336.40)</b>

## ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК ХХК

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр

Өмчийн өөрчлөлтийн тайлан

мян.төг

Үзүүлэлт	Хувь нийлүүлсэн хөрнгө	Нэмж төлөгдсөн капитал	Халаасны хувьцаа	Дахин үнэлгээний нэмэгдэл	Бусад өөрийн хөрөнгө	Хуримтлагсан ашиг	Нийт дүн
<b>2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	35,130,000.00	-	-	4,260,124.70	-	(113,436,093.70)	(74,045,968.20)
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	-	-	-	12,165,308.40	12,165,308.40
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-
Хуваарилсан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-
<b>2019 оны 12-р сарын 31-ны залруулагдсан үлдэгдэл</b>	35,130,000.00	-	-	4,260,124.70	-	(125,601,402.10)	(86,211,276.60)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	(529,101.30)	-
<b>2019 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	35,130,000.00	-	-	4,260,124.70	-	(125,072,300.80)	(85,682,175.30)
Залруулга	-	-	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	-	-	-	(69,203,336.40)	(69,203,336.40)
Бусад дэлгэрэнгүй орлого	(19,070,000.00)	-	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	(19,070,000.00)
<b>2018 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	54,200,000.00	-	-	4,260,124.70	-	(55,868,964.30)	2,591,160.30





## ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК ХХК

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр

Мөнгөн гүйлгээний тайлан

	2020	2019
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал)	12,169,199.20	(6,920,336.40)
<b>Орлого, зардлын тохируулга</b>	(14,180,360.80)	53,922,833.20
Эрсдэлийн сангийн зардал (+)	2,255,900.60	49,698,726.70
Элэгдэл, хорогдлын зардал (+)	806,161.90	929,139.30
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого (-), зардал (+) (Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөөс бусад)	1,362,161.60	(57,355.20)
Хуримтлуулсан хүүгийн орлого (-)	(2,935,255.60)	(16,754,275.20)
Хуримтлуулсан хүүгийн зардал (+)	7,968,992.40	23,147,627.90
Хөрөнгө данснаас хассаны олз (-), гарз (+)	906,357.60	-
Бусад олз (-), гарз (+)	(24,544,679.30)	(3,041,030.30)
<b>Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн тохируулга</b>	(26,286,158.20)	30,968,815.50
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн өсөлт (-), бууралт(+)	-	4,011,232.80
Арилжааны үнэт цаасны өсөлт (-), бууралт (+)	-	5,000,000.00
Зээлийн өсөлт (-), бууралт (+)	13,956,515.00	36,754,302.20
Бусад санхүүгийн хөрөнгийн өсөлт (-), бууралт(+)	(23,702,610.90)	(5,672,902.80)
Бусад санхүүгийн бус хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	12,542,132.40	8,551,187.10
Харилцах, хадгаламжийн өсөлт (+), бууралт (-)	(33,764,818.50)	(2,113,008.50)
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн өсөлт (+), бууралт (-)	13,828,583.20	(50,248,314.60)
Бусад санхүүгийн өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	421,454.60	(1,145,922.90)
Бусад санхүүгийн бус өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	(9,567,414.00)	(167,757.80)
<b>Бусад тохируулга</b>	(7,232,453.50)	4,524,574.00
Авсан хүү (+)	2,569,666.60	30,681,672.10
Төлсөн хүү (-)	9,520,868.10	(26,043,445.10)
Орлогын татварын төлөлт	(3,890.80)	(97,130.10)
Эрсдэлийн сангаас хаасан олз, гарз	(256,615.60)	-
Бусад	22,745.70	(16,522.80)
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(35,531,773.40)</b>	<b>20,212,886.10</b>

## ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК ХХК

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр

Мөнгөн гүйлгээний тайлан

мян.төг

	2020	2019
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	(125,500.00)	564,700.00
Борлуулахад бэлэн үнэт цаас борлуулсны орлого	(125,500.00)	564,700.00
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	(7,415,939.50)	(497,660.70)
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(872,269.60)	440,522.70
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(6,543,670.00)	57,137.90
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(7,541,439.60)</b>	<b>67,039.40</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	11,432,835.20	(29,294,376.30)
Бусад эх үүсвэр татаж хүлээн авсан	(203,371.90)	(224,377.20)
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан Хоёрдогч өглөгөөс хүлээн авсан	11,636,207.10	(19,069,999.10)
Бусад	-	(10,000,000.00)
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	407,231.90	6,304,146.20
Бусад эх үүсвэрт төлсөн	407,231.90	6,304,146.20
Бусад	-	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(11,025,603.30)</b>	<b>(35,598,522.60)</b>
Валютын ханшийн зөрүү	249,364.80	370,222.90
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(31,798,244.80)</b>	<b>(14,948,374.20)</b>
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>33,802,678.80</b>	<b>18,751,053.00</b>
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>2,004,434.00</b>	<b>33,802,678.80</b>





*Боломж их багадаа биш, хэдий хэмжээгээр  
Хүсч байгаад л учир нь байдаг.*

*Хаяг: УБ, СБД, 3-р хороо, Усны  
гудамж-1 тоот*

*Холбоо барих: 1800-1188*